



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

Төлөвлөгөөг хянасан:

Төсвийн ерөнхийлөн захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА /Д.ДЭЛГЭРСАЙХАН/

(албан тушаал)
Тэмдэг

(гарын үсэг)
2023.11.27
(огноо)

Төлөвлөгөө тайлагнасан:

Төсвийн шууд захирагч

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА /Б.ЦЭДМАА/

(албан тушаал)
Тэмдэг

(гарын үсэг)
2023.11.27
(огноо)



Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт/хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
ЗОРИЛГО: УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ.							
“Алсын хараа-2050” зорилт 5.3, 7.4, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, 7.4, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1, Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө, “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр”-ийн 3.3.4.4							
Зорилт1. Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.							
1.1	Өвөрхангай аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн барилгын орчин нөхцөлийг сайжруулах	Орон нутгийн төсөв 10,0 сая.төг	Барилгын чанар нөхцөлийг сайжруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	2	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн "Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 109 дүгээр тогтоолоор мэргэжлийн хяналтын байгууллагын бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг манай хэлтэст балансаас балансад шилжүүлэх шийдвэр гарсан. Улмаар аймгийн Засаг даргын тамгын газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр мэргэжлийн	100%

						хяналтын байгууллагын өмчид байсан байрыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүлээлцэж, тус хэлтэст хүлээлгэн өгснөөр 2023 оны 05 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа шинэ байранд явуулж байна. Өвөрхангай аймгийн Засаг даргын А/70 захирамжаар Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 19,458,860 төгрөгийг шийдвэрлүүлж камержуулалт, болон гадна, дотор тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Мөн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн №А/710 дугаартай захирамжаар хэлтсийн эзэмшлийн 2000 мкв газрыг 3036 мкв болгон хэмжээг нэмэгдүүлсэн шийдвэр гаргуулаад байна.	
1.2	Бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмжийг орон нутгаас шийдвэрлэх	Орон нутгийн төсөв 5,0 сая төгрөг	Шинэчилсэн тоног төхөөрөмжийн тоо	2	2	Тайлант хугацаанд Хархорин, Гучин-Ус, Баян-Өндөр, Богд, Хайрхандулаан сумдад ГЭРЭГЭ төлбөрийн киоск машин тавигдсанаар бүртгэлийн үйлчилгээг ард иргэдэд шуурхай хүртээмжтэй болгох нөхцөл бүрдсэн. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасагт HP130 маркын 3 үйлдэлт принтерийг 850,000 төгрөгөөр үйлчилгээндээ авч хэрэглэсэн ба аймгийн Засаг даргад 09 дүгээр сарын 28-ны өдрийн 581 тоотойр аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан энэхүү арга хэмжээнд анхаарч дэмжлэг үзүүлж ажиллахыг хүссэний дагуу 3 үйлдэлт принтер 2 ширхэгийг 2100.000 /хоёр сая нэг зуун мянга/ төгрөгийн санхүүжилтээр шийдвэрлүүлээд байна.	100%

1.3	Тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулах		Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн хувь	31	40	Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Монгол Улсын 16 насанд хүрсэн иргэн бүрт тоон гарын үсгийг иргэний хүсэлтээр, оршин суугаа газрын харьяалал харгалзахгүйгээр иргэний үнэмлэхийн санах ой буюу чипэнд суулган олгож эхэлсэн, 2022 оны 08 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн тоон гарын үсэг гар утасны аппликейшинээр дамжуулан иргэдэд олгож байна. 2023 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар давхардсан тоогоор 47.200 иргэн буюу аймгийн хэмжээнд тоон гарын үсэг авбал зохих иргэдийн 60 хувьд олгоод байна.	100%
1.4	Бүртгэлийн үйлчилгээг мэдээллийн технологийн арга хэрэгслээр үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх		Тоон гарын үсэг олгох,бусад байгууллагын цахим /киоск/ машины тоо	1	1	Тус аймгийн улсын бүртгэл нь бүртгэлийн үйлчилгээний цахим машин /киоск/-аар иргэдэд өөртөө үйлчлэх булан нээж, иргэний улсын бүртгэл, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээ, тоон гарын үсэг олгох /гар утсанд, иргэний үнэмлэхэнд/, зарим төрлийн лавлагааг үнэ төлбөргүй олгох, үйлчилгээний төлбөр төлөх боломжоор ханган ажиллаж байна. Мөн бүртгэлийн үйлчилгээний хөлс төлөх болон тоон гарын үсэг олгох ГЭРЭГЭ /киоск/ машиныг хэлтсийн байранд ашиглаж байна. Тус аймгийн 11 суманд ГЭРЭГЭ киоскийг нэвтрүүлж төлбөр төлөх болон тоон гарын үсэг олголтыг хийж цахимаар бүртгэл хийлгэх цахим үйлчилгээ авах боломжыг бүрдүүлэн ажиллаж байна. Төрийн үйлчилгээний цахим машинаар/ТҮЦ/, Улсын бүртгэлийн цахим машин//киоск/-р 2023 онд давхардсан тоогоор 4000 гаруй иргэнд тоон гарын үсгийг олгосон. Аймгийн хэмжээнд 2022-2023 онд 47.200 иргэнд цахим гарын үсгийг гар утсанд болон иргэний үнэмлэхэнд олгосон байна. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр тус аймгийн хэмжээнд 11 суманд цахим /киоск/ машиныг суурилуулсан.	100%

1.5	Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг холбогдох хууль тогтоомжинд нийцүүлэн боловсруулах, сурталчилах	-	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрлэлтийн сурталчилгааны тоо	3	3	Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын А/1863 дугаартай тушаал, "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг цахим системд хөтлөх журам", Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн 5/4664 дугаартай "ЭУБ-10,ЭУБ-14,ЭУБ-15 маягтуудын нэмэлт өөрчлөлт болон шинээр батлагдсан маягтууд, мөн 5/3367, 5/1854, 5/4053, 5/4664, 5/3367 дугаартай чиглэлүүдийг хэлтсийн 46 алба хаагчид нийт 7 удаагийн танилцуулга хийгдсэн. Тухайн журмын өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэгч байгууллага болох Хаан, Хас, Төрийн, Голомт банкуудын эдийн засагч нарт 2023 оны 05 дугаар сард журам, зааврын өөрчлөлтүүдийн талаарх нэгдсэн сургалтуудыг зохион байгуулсан. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 71 дүгээр тогтоолоор батлагдсан "Үндэсний энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам"-ыг нийт хэлтсийн алба хаагчдад танилцуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах талаар мэргэжил арга зүйгээр ханган, ирсэн чиглэлийн дагуу үндэсний энгийн болон цахим гадаад паспортыг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэх, баталгаажуулах, олголтод хяналт тавин ажиллаж байна. Мөн аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас зохион байгуулсан сумдын ахлах мэргэжилтэн, удирдлагуудад 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр онлайнаар хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр мэдээлэл хүргэн, бүрдүүлэх материалын жагсаалтыг цахим хаягаар хүргүүлэн ажилласан. Сургалт зохион байгуулсан тоо-3, хамрагдсан алба хаагчид-120, иргэн,хуулийн этгээд-32 байна.	100%
Зорилт 2.Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.							

2.1	E-mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн порталаар үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээг сурталчлах, аймгийн хэмжээнд үзүүлсэн цахим бүртгэлийг нэмэгдүүлэх.	-	Хүсэлт илгээсэн иргэдийн бүртгэлийг баталгаажуулсан хувь	100	100	Төрийн үйлчилгээний нэгдсэн портал E-mongolia-аар үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээг байгууллагын цахим хаяг, фэйсбүүк хаяг, орон нутгийн телевиз, мэдээ, шторк хэлбэрээр иргэдэд сурталчилсан. Тайлант хугацаанд E-mongolia системээр гадаад паспортын бүртгэл 41, иргэний үнэмлэх 112, иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл тайлант хугацаанд хийгдээгүй байна. Нийт 153 иргэнд бүртгэлийг хийлгэж, иргэдэд шуурхай хүргүүлсэн. Үйлчилгээний зааланд байршуулсан "Цахим туслагч" булангийн зөөврийн компьютераар "E-Mongolia" системээр дамжуулан эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр банк болон банк бус санхүүгийн байгууллагын зээлийн дараах болон бусад лавлагаа 1315, иргэнд 2315, иргэний бүртгэлээр 5724 лавлагааг олгов. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр тайлант хугацаанд 1663 оноосон нэрийн хүсэлтийг биечлэн болон цахимаар хүлээн авч баталгаажуулсан. Үүнд: service.e-mongolia-474, les.e-business.mn-ээр илгээсэн 815 хүсэлт ирснээс оноосон нэр авах 1253, нэрээ өөрчлөх 1, цахим гэрчилгээ 25, шинээр хуулийн этгээд байгуулах хүсэлт 10 байсныг хүлээн авч боловсруулан зохих журмын дагуу бүртгэсэн. Мөн улсын бүртгэлийн цахим киоск машинаас 292 хуулийн этгээд лавлагаа авч үйлчлүүлсэн байна.	100%
2.2	Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжид шилжүүлэх	-	Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байгаа сумын тоо	4	2	Улсын бүртгэлийн ерөнхий газрын төлөвлөгөө болон хэлтсийн төлөвлөгөөнд тусгасны дагуу эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн эрх олгох шалгалтанд шаардлага хангасан Богд, Есөнзүйл, Сант, Хархорин сумын улсын бүртгэгчид эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд хөтлөн явуулж өдөр тутмын үйл ажиллагаагаа иргэдэд түргэн шуурхай хүргэснээр сумын иргэд, аймгийн төв явахгүйгээр эд хөрөнгийн эрхийн бүх төрлийн үйлчилгээг тухайн сумын улсын бүртгэгчээс	100%

						<p>түргэн шуурхай авах нөхцөл бүрдүүлсэн. Жилийн эцсийн байдлаар Богд сумын улсын бүртгэгч 50 бүртгэл, Сант сумын улсын бүртгэгч- 91 бүртгэл ,Есөнзүйл сумын улсын бүртгэгч- 30, Хархорин сумын улсын бүртгэгч-1599 бүртгэл, нийт 1770 бүртгэлийг анхан шатны нэгжээс үзүүлээд байна. Уянга, Бүрд, Бат-Өлзий, Хужирт, Баянгол, Нарийнтээл, Хайрхандулаан сумдын бүртгэгч Хуулийн этгээдийн улсын бүртгэгч У.Должинсүрэн нарт эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн эрх нээлгэхээр санал хүргүүлэн. УБЕГ-аас зохион байгуулсан онлайн сургалтанд болон хэлтсийн байранд танхимын сургалтанд ажлын 7 хоногоор хамруулан дадлагажуулаад байна. Хэлтсийн нийт 19 сумдын бүртгэгч нарыг эрхзүйч мэргэжлээр сургасан. Мөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Ч.Нямлхагва, Г.Одончимэг нар хуулийн этгээдийн бүртгэл хийх эрх авсан ба нийт 40 бүртгэл хийгээд байгаа нь нэгжид эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийг зэрэг хийж байгаа анхны бүртгэгч нарын нэг болсон гэж үзэж байна.</p>	
2.3	<p>Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болох бүртгэлийг цахимаар бүртгэх, системийн хэрэглээ, цахим хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэх</p>	-	<p>Цахимаар бүртгүүлэхээр системд холбогдсон банк,санхүүгийн байгууллагын тоо</p>	-	1	<p>Өвөрхангай аймагт байрлах Голомт банкны салбарын захиралтай 2 удаагийн уулзалтыг зохион байгуулж цахимаар бүртгэхийн ач холбогдол болон цахим хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэх талаар ярилцан Голомт банкны явуулын үйлчилгээг байгууллага дээрээ 9 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулаад байна. Мөн 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдөр “Хаан банк”-ны тооцооны төвийн эдийн засагч нарт сургалт семинар зохион байгуулсан. 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн ХААН банкнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу зээлийн барьцаа хөрөнгө шинээр бүртгэх, дуусгавар болгох өөрчлөлт оруулах тодорхойлолтыг тоон гарын үсгээр баталгаажуулж, цахимаар нэвтрүүлэхэд бэлэн болсон талаарх албан тоот ирүүлснийг судлан хадгалах хугацааны талаарх саналаа ХААН</p>	100%

						банкинд хүргүүлээд байна.	
			Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээний бүртгэлийн тоо	-	10	Тайлант хугацаанд ЭУБ-06 маягтаар 2900 бүртгэл, ЭУБ-13 маягтаар 810 бүртгэл нийт 3710 бүртгэл бүртгэгдсэн байна.	100%
			Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийн тоо	-	10	Тайлант хугацаанд барьцааны гэрээ дуусгавар болох бүртгэл 3714 бүртгэгдсэн байна.	100%
2.4	Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хөтлөгдсөн иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулах.	-	Цахимжуулсан иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтын тоо	15,000	17,000	Тайлант хугацаанд нийт 56.467 хуудас бүхий эх нотлох баримт бичгийг цахимжуулснаас нийт хөтлөгдсөн 22.366 бүртгэлийн 33.234 хуудас эх нотлох баримт бичиг, 3757 иргэний хувийн хэрэг, иргэний улсын бүртгэлийн маягт, хууль тогтоомжинд заасан нотлох баримт бичиг 18.785, хяналтын улсын байцаагчийн 691 хуудас бүхий 83 дүгнэлтийг цахимжуулаад байна.	100%
Зорилт 3.Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.							
3.1	Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг үнэлж, дүгнэлт гарган мэдээллийн санг цэгцлэх	-	Засвар хийгдсэн бүртгэлийн тоо	1644	1800	Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх ажлын хүрээнд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 603 иргэний мэдээллийг санд тусгуулсан, 1997-2007 онд төрсөн иргэдийн мэдээллийг шүүж, давхар регистрийн дугаартай, үндсэн мэдээллийн сан дахь төлөв тодорхойгүй 13 иргэний регистрийн дугаарыг хяналтын улсын байцаагчийн 2961, 5601 тоот дүгнэлтээр хүчингүй болгож, засварлан шийдвэрлэсэн, 04 дүгээр сарын 25-ны өдрийн "Зөрчил 2023" файлд байршуулсан	100%

					<p>өөрийн нэгжийн харъяалах 39 иргэний мэдээллийг нягтлан шалгаж заасан хугацаанд зөрчлийг арилган шийдвэрлэсэн, 05 дугаар сарын 25-ны өдрийн №3/5080 албан тоотын хавсралтын дагуу 23 иргэний ИУБ-31 бүртгэлийн мэдээллийг тус бүрээр шалган үзэхэд хурууны хээ шалгагдаагүй 22, үндсэн мэдээллийн санд зөрүүтэй 1 төлөвтэй байгааг хяналтын улсын байцаагчийн 3997 тоот дүгнэлтээр шийдвэрлэсэн. Мэдээллийн сан цэгцлэх ажлын хүрээнд иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн зөрчилтэй 1454 иргэний төрөлт, эцэг тогтоолт, үрчлэлтийн бүртгэлийн мэдээлэл цахим мэдээллийн санд дутуу бүртгэгдсэн байсныг шүүж, мэдээллийн санд нягтлан шалгаж, цахимжуулалт хийгдээгүй 423 иргэний хувийн хэргийг цахимжуулан, мэдээллийн санд засвар өөрчлөлт хийж, мэдээллийн сан цэгцлэх ажлыг хийсэн. Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 806 тоот хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр шинээр байгуулсан хуулийн этгээд болон мэдээллийн санд орсон өөрчлөлтийг бүртгэхдээ улсын бүртгэлийн архивын эх нотлох баримт, мэдээллийн сан дахь цахимжуулсан баримтаас зөрүүтэй бүртгэсэн бүртгэлийг хуулийн этгээдийн ахлах бүртгэгч нар тухайн хуулийн этгээдийн хүсэлт, бүртгэгчийн тайлбарыг үндэслэн засварлах эрх олгосны дагуу тайлант хугацаанд 7 хуулийн этгээдийн зөрүүтэй мэдээллийг хүргүүлэн засварлуулан, баяжилтыг цаг тухай бүр хийн ажилласан. Мөн УБЕГ-ын хяналтын улсын байцаагчийн 2023 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 5051 тоот дүгнэлтээр “Онги ус суваг” хуулийн этгээдийн хэлбэр ХХК/ОНӨ/ байхыг ОНӨААТҮГ гэж буруу бүртгэсэн байсныг засварлуулан гэрчилгээг дахин олгон ажилласан. Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн нийт 5 чиглэлийн</p>	
--	--	--	--	--	--	--

						дагуу эд хөрөнгийн эрхийн бүртгэлээр цахимжигдах явцад нотлох баримтаас зөрүүтэй цахимжигдсан 4425 бүртгэлд хяналтын улсын байцаагчийн 2022 оны 1500 дүгнэлтийн дагуу цахим мэдээллийн санд засвар өөрчлөлтийг хийж, мэдээллийн санг цэгцлэх ажлыг хийсэн байна.	
3.2	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих.	-	-Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хувь.	100	100	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд онцгой анхаарч хэлтсийн хэмжээнд хуулийн дагуу тайлант хугацаанд мэдээллээ бүрэн байршуулсан. Хуулийн хугацаанд 128 мэдээ байршуулахаас 128 мэдээ байршуулсан. Хугацаа хоцролттой дутуу байршигдсан мэдээ байхгүй хуулийн хэрэгжилт 100 хувьтай байна. Тухай бүрийн мэдээнд тайлант хугацаанд өссөн дүнгээр 873,745,400 төгрөгийн урсгал санхүүжилт, 137,800,715 төгрөгийн үйлчилгээний орлогыг төвлөрүүлэх шилжүүлгийн зарлагын гүйлгээ зэргийг хуулийн хугацаанд байршуулан ажилласан. Өмнөх оны аудитын тайлан дүгнэлт, санхүүгийн жилийн эцсийн тайланг хуулийн хугацаанд байршуулсан. Тус онд байгууллагын бүтэц орон тоонд гэрээт албан хаагчаар 2 харуул хамгаалалт, 1 үйлчлэгч нийт 3 гэрээт албан хаагч авч ажиллуулан мөн төрийн захиргааны 1 албан хаагч хүүхдээ асрах жирэмсний чөлөө авсан, 1 албан хаагч жирэмсний амралттай байна. Бүтэц орон тооны өөрчлөлтийн хөдөлгөөнийг тухай бүрийн мэдээнд тусган ажилласан.	100%
3.3	Улсын бүртгэлийн байгууллагын байрны ашиглалт, үнэт цаас, маягт,	-	Төрийн өмчийн эд хөрөнгийн тооллогыг цаг тухайд хийсэн болон ашиглалтгүй	100	100	Тайлангийн хугацаанд төсвийн хөрөнгийг зүй зохистой, нээлттэй байдлаар хууль тогтоомжийн дагуу үргүй зардал гаргахгүй хэмнэлттэй байдлаар зарцуулсан. Монгол улсын засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 28,29 өдрүүдийн үл хөдлөх хөрөнгө	95%

	бараа материалын хангалт, үйлчилгээг хариуцан зохион байгуулах зарцуулах, тайлагнах		хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх хувь;			балансаас балансад шилжүүлэх тухай 109,126 дугаар тогтоолоор барилга, байгууламж 1,324,326,565 төгрөг, газар 38,484,000, тоног төхөөрөмж 41,487,655 төгрөг, тавилга, эд хогшил 20,991,770.85 төгрөг, бусад биет бус хөрөнгө 713,000 төгрөг, нийт 1,465,590,395.85 төгрөгийн үндсэн хөрөнгийг тус тус бүртгэлд тусгасан. Улсын бүртгэлийн ерөнхий газраас 20,668 ширхэг нийт 12,051,910 төгрөгний үнэтэй үнэт цаасны татан авалт хийсэн. Хэлтсийн даргын 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/06, 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/07 дугаар тушаалаар тус тус төрийн өмчийн эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр тоолон тооллогын комиссын хурлын тайлан гарган ажилласан.	
3.4	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулах, тайлагнах, байршуулах.	Урсгал төсөв /593,4 сая төгрөг/	Тайлагнаж, байршуулсан мэдээллийн тоо.	4	4	Төсөвт байгууллагын санхүүгийн нэгдсэн тайланг 4 удаа улирлаар, төсвийн гүйцэтгэлийн мэдээг 12 удаа сараар гаргаж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Санхүү аж ахуйн хэлтэст хугацаанд нь хүргэсэн байна. Мөн улсын төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулан өр төлбөр үүсгэхгүйгээр санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолыг мөрдөн ажиллаж тэвчиж болох зардлыг хэмнэн 0 төгрөгийн үлдэгдэлтэй, өр авлага үүсгэлгүй ажилласан байна. 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтээр өөрчлөлтгүй дүгнэгдсэн.	100%
3.5	Хуулийн этгээдийн бүртгэлийн архивын баримтад тооллого хийх	-	Тооллого хийсэн эсэх	-	1	Тус хэлтсийн хувьд шинэ суурьшлын бүсэд шинэ байранд орсонтой холбогдуулан бүртгэлийн архивын хадгалалтын нөхцөл сайжирсан ба архивын баримтыг төлөвлөгөөний дагуу нүүлгэн шилжүүлэлт хийж байршуулсан. Хэлтсийн даргын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/05 тоот тушаалаар тооллогын комиссыг томилон, бэлтгэл ажлыг ханган ажлын удирдамжийг хэлтсийн даргаар батлуулан тооллогын комиссыг хуулийн этгээд, эд хөрөнгийн тасгийн	100%

						<p>7 хүний бүрэлдэхүүнтэйгээр тооллогын ажлыг зохион байгуулсан. Тооллогод 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэлх нийт 2242 хуулийн этгээдийн бүртгэл хамрагдсанаас ТББ-289, ШБ-18, Сан-10, ҮЭБ-26, ХМБ-7, БСБ-2, хоршоо-214, нөхөрлөл-132, ТБАГ-193, ТБАГУТҮГ-14, УТҮГ-4, ОНӨААТҮГ-5, ТӨАТҮГ-1, ХХК/11/-1299, ХК-5, ХХК/ТБОНӨ/-6, ХХК/Аудит/-1, ХХК/ХМБ/-1, ХХК/өмгөөллийн/-2, ХХЗ/БСБ/-3 хэлбэртэй хуулийн этгээд тус тус байна. Тооллогын явц 2 үе шаттайгаар явагдсан ба эхлээд архивын эх нотлох баримтыг нэг бүрчлэн тоолж, дараа нь цахим сангаас тулгалт хийн, хуудасны дугаар зөрүүтэй хуулийн этгээдийн хувийн хэргийг архиваас татан авч шалган ажиллав. Мөн тооллогын явцад байршуулах дараалал алдагдсан хувийн хэргийг байршуулах, хувийн хэргийн хавтас гэмтсэн засан сэлбэх шаардлагатай хувийн хэрэг байсныг шинэчлэх ажлыг зохион байгуулсан. УБ хотод хяналтын дугаар олгосон болон мэдээлэлд өөрчлөлт орсон, лавлагаа, хуулбар олгосон бүртгэл хийгдсэн боловч эх нотлох баримт нь ирээгүй 12 зөрчил илрээд байна. Тооллогын явцад алгассан улсын бүртгэлийн дугаар, татан буугдсан аж ахуй нэгжийн судалгаа, шилжин явсан хуулийн этгээдийн судалгааг гарган ажилласан.</p>	
3.6	Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих замаар улсын бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг хангах.	-	Хяналт шалгалтын хэрэгжилтийн хувь	100	100	<p>Улсын бүртгэлийн хууль тогтоомжид хяналт тавьж, улсын бүртгэлийг үнэн зөв байх зарчмыг хангах үүднээс 8 сумын улсын бүртгэгчийн 7800 гаруй бүртгэлд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулж ажиллалаа. Мөн 10 иргэний регистрийн дугаарыг төрөлтийн бүртгэлд үндэслэн өөрчлөх 10 дүгнэлт, 3 иргэний регистрийг сэргээж бүртгэлийг мэдээллийн санд оруулах 3 дүгнэлт, эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх 7 иргэний 1 дүгнэлт, эд хөрөнгийн гэрчилгээ үрэгдүүлсэн 25 гэрчилгээг хүчингүйд тооцох 21 дүгнэлт, төрөлтийн бүртгэлд зөрүүтэй бүртгэгдсэн 13</p>	100%

						иргэний төрөлтийн мэдээллийг үндсэн санд зөв болгох 13 дүгнэлт нийт 58 иргэний зөрүүтэй, үрэгдүүлсэн бүртгэлийг засварлах 48 дүгнэлт гаргаж ажилласан. Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх ажлын хүрээнд үндсэн сангийн мэдээлэл зөрчилтэй 129 иргэний мэдээллийг засварлах 12 дүгнэлт, гэрлэлт ургийн овог зөрүүтэй 25 иргэний зөрчлийг засварлах 21 дүгнэлт, гэрлэлт давхар бүртгэгдсэн 1, регистрийн дугаар давхар бүртгэгдсэн 13 иргэн, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд зөрчилтэй бүртгэгдсэн 22 иргэний бүртгэлийн хүчингүй болгох 3 дүгнэлт нийт 168 иргэний мэдээллийг санд засварлах, 35 иргэний давхар бүртгэлийг хүчингүй болгох 37 дүгнэлт гаргаж мэдээллийн санг цэгцэлсэн.	
3.7	Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэх.	-	Зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн хувь	100	100	Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэний үнэмлэх хаяж үрэгдүүлсэн 42 иргэнд 1260 мянга, гэмтээж хүчингүй болгосон 3 иргэнд 75 мянга, хугацаанд нь сунгуулаагүй 86 иргэнд 1720 мянга, гадаад паспорт гэмтээсэн 1 иргэнд 25 мянга, нийт 132 иргэнд 3 сая 80 мянган төгрөг, 1 хуулийн этгээдэд 500 мянган төгрөгний шийтгэлийн зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлээд байна. Аймгийн Прокурорын газарт хууль журамд заасны хугацаанд зөрчлийн санд тухай бүр бүртгүүлэн мэдээ тайланг заасан хугацаанд тайлагнан ажиллаж байна.	100%
3.8	Хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж, батлан, хэрэгжүүлж ажиллах	-	-Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	100	100	Хяналт шалгалтын төлөвлөгөөг 4 зүйл, 12 заалттайгаар төлөвлөн хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилт 90 хувьтай байна. Энэхүү төлөвлөгөөний дагуу 5 сумын 6 улсын бүртгэгчийн бүртгэл хөтлөлтийн явцад хяналт тавьж, иргэний улсын бүртгэлийн 319, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 73, хуулийн этгээдийн бүртгэлд 24 хяналт шалгалт хийж иргэний бүртгэлээр 61, эд хөрөнгийн бүртгэлээр 22, хуулийн этгээдийн бүртгэлээр 2,	100%

						нийт 85 дүгнэлт гаргаж, 132 иргэнд 3 сая 80 мянган төгрөг, 1 хуулийн этгээдэд 500 мянган төгрөгийн шийтгэл оногдуулж ажиллалаа. Нийт 133 иргэн, хуулийн этгээдэд 3.580 мянган төгрөгийн шийтгэл оногдуулсан.	
3.9	Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөх	-	Улсын бүртгэлд зөрчилгүй бүртгэсэн бүртгэлийн хувь	99	100	Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр тайлангийн хугацаанд нийт 22.366 бүртгэлийг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу бүртгэж, баталгаажуулаад байна. Үүнд: төрөлт 1879, гэрлэлт 313, гэрлэлт сэргээлт 1, гэрлэлт цуцлалт 80, эцэг тогтоолт 61, ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний 111, үрчилсний 33, нас барсны 638, иргэний үнэмлэхийн дахин олголт 715, үүнээс хаяж үрэгдүүлсэн 509, дүр төрх өөрчлөгдсөн 62, хүчинтэй байдлаа алдсан 2, овог нэр сольсон 19, төрсөн он, сар, өдөр тогтоолгосон 5, цахимаар захиалсан 112, хугацааны сунгалт 2424, шинээр 1607, үндэсний энгийн гадаад паспорт 3450, шилжилт хөдөлгөөний бүртгэл 5494 тус тус бүртгэж баталгаажуулсан. Тайланд хугацаанд 8097 лавлагаа олгосноос хууль хяналтын байгууллагад албан бичгээр 467, албан хэрэгцээнд 373, иргэнд 7257 лавлагаа олгосон байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 1938 хүсэлт хүлээн авсан. Үүнд: ers.gasr.mn 649, service.e-mongolia 474, les.e-business.mn 815. Шинээр байгуулагдсан 238, мэдээлэлд өөрчлөлт оруулсан бүртгэл 229, салбар төлөөлөгчийн газрын бүртгэл 16, шилжилт хөдөлгөөн 13/шилжин ирсэн-8, явсан-5/ , татан буугдсан 8, шинэ оноосон нэрийн хүсэлт 342, оноосон нэр өөрчилсөн 18, хэлбэр өөрчилсөн 14, дахин гэрчилгээ олгосон 50, тамга тэмдгийн хяналтын дугаар олгосон 264, тамга тэмдэг хураан авсан 46, эцсийн өмчлөгч нөхөн бүртгэсэн 25, эцсийн өмчлөгчийн нэмэлт	100%

						өөрчлөлт 65, лавлагаа хуулбар 165 олгон ажилласан байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр анхны бүртгэл-1019, өмчлөх эрх шилжих гэрээ-1890, барьцааны гэрээ-7799, бүртгэлд өөрчлөлт оруулах-674, нийт 12189 цахим суурьт бүртгэл хийж баталгаажуулсан байна.	
3.10.	Улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулах	-	“Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулсан тоо;	28	10	Хархорин, Хужирт, Бат-Өлзий, Уянга, Хайрхандулаан, Тарагт, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Есөнзүйл, Баян-Өндөр, Богд, Баруунбаян-Улаан Төгрөг сумдын засаг даргын тамгын газар, иргэдийн төлөөгчдийн хуралтай хамтран “Нээлттэй өдөрлөг”-ийг тус оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс 11 дугаарын сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан. Уг өдөрлөгийн үеэр иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 1050 гаруй иргэнд мэдээ мэдээлэл өгч, 825 иргэнд бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, өрхийн эмнэлэгүүдэд 03 дугаар сарын 01-ний өдрөөс 05-ны өдрийн хооронд “Нээлттэй өдөрлөг”-ийг зохион байгуулж, бүртгэлийн чиглэлээр 115 иргэнд үйлчилгээ үзүүлж, 72 иргэнд тоон гарын үсэг олгосон.	100%

3.11	Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэл, зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажил	-	Тухайн ажлыг хугацаанд нь хийж хэрэгжүүлсэн байдал хувиар	100	100	<p>Улсын бүртгэлийн ерөнхий газраас нийт 17 чиглэл зөвлөмж ирснээс эд хөрөнгийн эрхийн 16, иргэний улсын бүртгэлийн 7, хуулийн этгээдийн 8, бусад 2 байна. Үүнээс хариутай 3, хариугүй 12. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/600 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчийн хурлын сонгуулийн тухай хуулийг /нөхөн/ хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө”-ний хүрээнд ирсэн чиглэлийн дагуу Арвайхээр, Хархорин сумын шилжилт хөдөлгөөний 552 бүртгэлд хяналт тавьж хийж, заавар зөвлөмж өгч, тайланг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлж ажиллав. 04 дүгээр сарын 06-ны өдрийн 3/3164 тоот чиглэл, 04 дүгээр сарын 23-ны 3/3791 тоот чиглэл, 01 сарын 18-ны 1/102 тоот чиглэл, 05 дугаар сарын 25-ны өдрийн 3/5090 тоот чиглэл, 04 дүгээр сарын 21-ний өдрийн 6/3684 тоот чиглэл, 04 дүгээр сарын 25-ны 3/3791 тоот чиглэлүүдийг хэлтсийн алба хаагчид танхимаар, сумдын бүртгэгчид цахимаар танилцуулж чиглэлийн дагуу илтгэх хуудсыг иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн улсын бүртгэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 5/1854 чиглэлийн дагуу цахим мэдээллийн санд хувийн хэрэг хаах үйлчилгээ бүртгэгдсэн боловч өмчлөгчийн төлөв өөрчлөгдөөгүй өмчилсөн төлөвтэй газрын 14 бүртгэл, газраас бусад үл хөдлөх хөрөнгийн 16 бүртгэлийн төлөвийг, 6/277 чиглэлийн дагуу эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд 84 бүртгэлд засвар өөрчлөлт, 5/4053 чиглэлийн дагуу цахим мэдээллийн санд газрын зориулалт буруу цахимжсан 2320 бүртгэлийг цахим мэдээллийн санд шалгаж газрын зориулалтыг, 5/4618 чиглэлийн дагуу цахим</p>	100%
------	---	---	---	-----	-----	---	------

						мэдээллийн санд газрын нэгж талбарын дугаар оруулаагүй 1873 бүртгэлийг цахим мэдээллийн санд шалгаж нэгж талбарын дугаарыг тус тус нөхөж оруулсан байна. УБЕГазраас ирүүлсэн нийт 5 чиглэлийн дагуу 4425 бүртгэлд хяналтын улсын байцаагчийн 1500 дүгнэлтээр засвар өөрчлөлтийг бүртгэсэн. Мөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллах 3 чиглэл, зөвлөмж хүргүүлэх тухай 8 чиглэлийг тухай бүр нь бүртгэгч нарт танилцуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.	
3.12	Шинэлэг, бүтээлч ажил зохион байгуулах	-	Шинэлэг ажил зохион байгуулсан тоо	3	3	Хэлтсийн шинэ байрны гадна талбайн ногоон байгууламжид 12 ширхэг жимсний бут, 60 ширхэг хайлаас, 3 цэцгийн мандалд 65 ширхэг цэцгийн үрслэгээ, 70мкв газрын зүлэгжүүлэлт хийж, 30 ширхэг тасалгааны цэцгийг тарьж ургуулсан. Хэлтсийн гаднах хайс, болон гадна талбайг будаж, өнгө үзэмжийг сайжруулж нийт 5 самбар, буланг шинээр тохижуулав. Нийт төсөвт өртөг 10 сая төгрөг. 4 дүгээр сарын 24-ний өдөр аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын газартай хамтран гэрлэлтээ батлуулж буй залуучуудыг гэр бүлийн харилцаа, гэрлэлтийн үнэ цэнэ, угийн бичиг хөтлөхийн ач тус сэдвүүдээр залуучуудын хөгжлийн төвийг түшиглэн сургалтанд хамруулж 10 иргэнд гэрлэлтийн батламж гардуулсан. Улсын бүртгэлийн ажилтны өдрийг угтаж 10 дугаар сарын 15-аас 11 дүгээр сарын 15-ны өдрийн хугацаанд сарын аяныг зохион байгуулан ажиллалаа. Үүнд: Бүх нийтийн идэвхтэй хөдөлгөөнийг дэмжин Буга согоотын өндөрлөгөөс Дэлгэрэх гол хүртэлх явган аялал хийж, голын эхийн хогийг цэвэрлэн, буухиа тэмцээн зохион байгуулсан, Хэлтсийн байранд шинээр 2 дасгал сурч ажлын байрны дасгалыг хэвшүүлээд байна. Хэлтсийн гаднах 200 мк талбайг жимсний модны цэцэрлэг болгохоор намрын мод тариалалтаар 23 ширхэг монос, улаалзгана, үхрийн нүд, нохойн хошууны	100%

						<p>суулгацыг тариалаад байна. Хэлтсийн шинэ байранд 30 мкв өрөөг өөрсдийн нөөц боломжоор тохижуулан ажилчдын хүүхэд саатуулах өрөөг ашиглалтанд оруулсан нь бусад аймгуудад үлгэр жишээ болохуйц шинэлэг ажил болоод байна. Мөн алба хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, ажлын байрны дасгалыг хэвшүүлэхэд анхаарч 1 өрөөг дасгалын зориулалтаар гүйлтийн зам, спиннинг дугуй, дартс, ханын турник, теннисний ширээ зэргийг байрлуулан тохижуулан ашиглаж байна. 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн өдрийн 9 цагаар цайны цагийн амралтгүйгээр зохицуулалт хийн хуваарь гарган, тасралтгүйгээр бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллаж байгаа нь онцлог ажил болоод байна.</p>	
3.13	Хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох	-	Хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон эсэх тоо	3	-	<p>Өвөрхангай аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхэд иргэн Доржхоролын Батбаатарын “Үрчлэлтийн бүртгэл хүчингүй болгож, төрөлтийн бүртгэлийг сэргээхийг Өвөрхангай аймгийн улсын бүртгэлийн хэлтэст даалгах” нэхэмжилэлтэй хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргуулсан. Иргэн Д.Сундуйгийн Г1014001082, Г1014001086 эрхийн улсын бүртгэлийг хүчингүй болгуулах нэхэмжлэлтэй хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр улсын бүртгэгч Г.Одончимэг, Ч.Нямлхагва нарыг томилон нэхэмжлэлийн хариу тайлбарыг хүргүүлэн мэдээллийн санд холбогдох мэдээллийг оруулан цахимжуулан ажиллалаа.</p>	100%

3.14	Орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах	-	Хамтран зохион байгуулсан ажлын тоо	1	2 Иргэдийн эрхзүйн боловсролыг дэмжих, хуульзүйн зөвлөгөө үнэ төлбөргүй өгөх "Хуульчийн Про боно-2023" өдөрлөгийн үеэр тус хэлтсийн алба хаагч 50 орчим иргэнд иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлж, байгууллагын чиг үүрэг үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөө мэдээллийг өгч, 31 иргэнд тоон гарын үсэг олгосон. Улсын бүртгэлийн ерөнхий газар, Хаан банктай хамтран "Тоон гарын үсэг идэвхжүүлэх аян"-ны хүрээнд тус хэлтэс нь 04 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн аймгийн хаан банктай хамтран "Цаг хугацааг хэмнэе" Хаан банкны үйлчилгээний зааланд иргэний улсын бүртгэлийн алба хаагчид батлагдсан хуваарийн дагуу тоон гарын үсэг олгож ажилласан. 04 дүгээр сарын 10-ны өдөр "Болор өрөг" ХХК-ны 46 ажилчинд тоон гарын үсэг олгосон. Аймгийн цэргийн штабаас 04 дүгээр сарын 19,20-ы өдрүүдэд зохион байгуулсан цэрэг татлагын үеэр 174 иргэнд, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн ажлын алба, нийгмийн даатгалын хэлтсийн 34 албан хаагчдад тоон гарын үсэг олгон бүртгэлийн үйл ажиллагааг сурталчилан ажилласан. Сумдын улсын бүртгэгчид багуудын иргэдийн нийтийн хурлын үеэр Улсын бүртгэлийн ерөнхий хууль, эд хөрөнгө, иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулиар танилцуулга хийж, гарын авлага тараан 50 гаруй тоон гарын үсэг олгосон. "The art of living" бясалгал иогийн нэгдсэн төвтэй хамтран 23 алба хаагчийг "Эрүүл амьдрахуй" сургалтад хамруулсан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газрын хамтарсан улсын хэмжээнд зохион байгуулж буй стратегийн команд штабын сургуулилтад 2023 оны 06 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд төлөвлөлтийн ажлын хэсэг тус хэлтсийн дарга орж ажиллаж дадлага сургууль хийв. Арвайхээр сумын ЗДТГ-тай хамтран Монгол	100%
------	---	---	-------------------------------------	---	---	------

						Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Баян намсрай” цэцэрлэгт хүрээлэнд 100 ширхэг модны нүх ухаж хайлаас, улиас модны суулгац тариалсан.Аймгийн төв номын сантай хамтран Соёлын бүтээлч сарын аяны хүрээнд “Уншлагыг дэмжье”аян болон Залуусын элч ТББ ,Амьдралын томилгоо-нэгдмэл хангай ТББ, Аймгийн Тагнуулын алба,Цагдаагийн газар, ИТХ, нийгмийн даатгал, Улаан загалмай зэрэг байгууллагуудтай хамтран хувь хүний хөгжил, хүүхдийн хүмүүжил, төрийн болон албаны нууцын тухай хууль, кибер аюулгүй байдлын тухай, иргэний болон байгууллагын ёс зүй зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулан хүүхдийн ид шидийн оронд хамт олоноороо хандив өгч, алба хаагчид бүгд улаан загалмайн идэвхтэн гишүүн болж 2 алба хаагч цусны донор болж хамтран ажиллалаа.	
Зорилт 4. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.							
4.1	Байгууллагын 2023 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	-	Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	Албан хаагчдын сургалт-хөгжил сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа. УБЕГазраас зохион байгуулсан 79 удаагийн онлайн сургалтанд холбогдох алба хаагчдыг хамруулсан. Хэлтсийн алба хаагчдыг түвшингээр нь 2 хуваан монгол бичгийн анхан болон дунд шатны 36 цагийн сургалтанд хамруулсан.	100%

4.2	Албан хаагчдын нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	-	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	100	100	<p>Хэлтсийн нийт 8 өрөөг өөрсдийн нөөц бололцоог ашиглан засварлаж, үйлчилгээний танхимын ширээ сандал, ханын шүүгээ, хүлээлгийн сандал зэргийг шинээр хийлгэсэн. Мөн байрны гаднах талбайд 3*3 хэмжээтэй сүүдрэвч шинээр барьсан ба ногоон байгууламжид нийт 78 мод, бут суулгаж 80 орчим мкв талбайд зүлэгжүүлэлт хийж, цэцгийн мандал 3-ыг шинээр хийсэн. Алба хаагчдын ажлын ачаалал, амралтын цагийг харгалзан үзэж амрах өрөө болон үдийн цай хийх зориулалттай өрөөг 1.250.000 төгрөгийг зарцуулан тохижуулав. Арвайхээр сумын ургацын талбайн бүс болох Дайргын голд 1 га талбайд ажилчдын хувийн хэрэгцээнд зориулан хүнсний ногоо тариалсан. Алба хаагчдын 5-12 насны 13 хүүхдийг аймгийн Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газартай хамтран ажиллах гэрээ байгуулан шатар, бүжгийн сургалтанд хамруулан, 79 хүүхдэд хүүхдийн баярын өдрийн тохиолдуулан 1,225,000 төгрөгний бэлгийг нэг удаагийн тэтгэмж урамшуулал болгон өгсөн. Төрийн үйлчилгээний 5 алба хаагчдад хэлтсийн даргын 2023.04.25-ны өдрийн Б/05 дугаар тушаалаар ур чадварын нэмэгдэл олгосон.</p> <p>Тус байгууллагад ажиллаж байсан 11 ахмадыг урьж, 550,000 төгрөгийн гарын бэлэг гардуулсан.</p> <p>Аймгийн БОЭТ-тэй хамтран нийт алба хаагчдыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулсан. БОЭТ-ийн шүд, эрүү нүүрний эмчийг урьж, “Амны хөндийн эрүүл ахуй-түүнээс үүдэн гарах өвчлөлүүд” сэдвээр алба хаагчдад танхимаар сургалт зохион байгуулсан.</p> <p>Хэлтсийн 1 өрөөг засвар хийн тохижуулж, бялдаржуулах танхим болгон ашиглалтанд оруулсан.</p>	100%
-----	--	---	-------------------------------	-----	-----	--	------